

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМ
МОНЦЕМЕНТ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН “СЭНЖИТ ХУДАГ”
ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРД 13681А ТООТ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОРЧНЫ ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-013681
ААН-ИЙН РЕГИСТРИЙН ДУГААР : МОНЦЕМЕНТ БИЛДИНГ МАТЕРИАЛС ХХК- 5106567**

Баталсан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

/ /

Тайлан гаргасан:

“Монцемент Билдинг Материалс” ХХК -ийн

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал



/Ц.Халиун/

Байгаль орчны мэргэжилтэн

/Т.Октябрь /

Улаанбаатар хот

2022 он

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМ
МОНЦЕМЕНТ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН “СЭНЖИТ ХУДАГ”
ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРД 13681А ТООТ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОРЧНЫ ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-013681
ААН-ИЙН РЕГИСТРИЙН ДУГААР : МОНЦЕМЕНТ БИЛДИНГ МАТЕРИАЛС ХХК- 5106567**

Баталсан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

/

/

Тайлан гаргасан:

“Монцемент Билдинг Материалс” ХХК -ийн

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

/Ц.Халиун/

Байгаль орчны мэргэжилтэн

/Т.Октябрь /

Улаанбаатар хот

2022 он

Гарчиг

1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн талаар мэдээлэл.....	4
Төслийн талбай орших газрын засаг, захиргааны харьяалал.....	4
Дэд бүтэц, зам харилцаа.....	4
Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал.....	5
Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагааны тухай мэдээлэл.....	6
2. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ.....	7
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН.....	8
3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	8
3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	8
3.3 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	9
3.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	9
3.5 Шимт хөрс хуулалт хадгалалт.....	10
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН.....	31
ИЛ ТАЛБАЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	37
5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН.....	38
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН.....	40
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТАЙЛАН.....	40
8. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН.....	42
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН.....	45
10. ХОГ ХАЯГДЛЫН ТАЙЛАН.....	49
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	55
12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЙЛАН.....	57
13. БОМТ-ӨӨГ СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ.....	64
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	67
ХАВСРАЛТУУД.....	68

Хүснэгтийн жагсаалт

ХҮСНЭГТ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ.....	
ХҮСНЭГТ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
ХҮСНЭГТ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	32
ХҮСНЭГТ 4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34
ХҮСНЭГТ 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	41
ХҮСНЭГТ 6. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ.....	43
ХҮСНЭГТ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	47
ХҮСНЭГТ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	51
ХҮСНЭГТ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
ХҮСНЭГТ 10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	59
ХҮСНЭГТ 11. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	64

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	Сэнжит худаг шохойн чулуун ордыг ил аргаар ашиглах төсөл
Төслийн хүчин чадал:	Жилд 1.3 сая тонн шохойн чулуу олборлох хүчин чадалтай
Байршил:	Дорноговь аймаг Өргөн сум
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Автозамчдын гудамж, Монполимет Комплекс.
Хариуцах хүн:	Байгаль орчны мэргэжилтэн Т.Октябрь. Утас: 99045481
БОННУ хийсэн	“Өндөрхаан трейд” ХХК
ААН-ийн нэр	
Батлуулсан огноо:	2022он

Хүснэгт 1. Сэнжит худгийн шохойн чулууны 2022 оны уулын ажлын төлөвлөгөөний биелэлт

СЭНЖИТ ХУДГИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ УУРХАЙН 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТАЙЛАН		
	Түүхий эд	Нийт
Уурхайгаас олборлох түүхий эд	Нийт шохойн чулуу, Эзэлхүүн мян.м3	262.271
	Хөрс /мян.м3/	28163
	Шимт хөрс Талбай /га/ Эзэлхүүн / мян.м3/	2.79
		7.016
	Нийт уулын цул /мян.м3/	226.100

2022 оны 10 сарын 29-ны байдлаар

1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн талаар мэдээлэл

“Сэнжит худаг” -ийн шохойн чулууны ордын тусгай 13681А тусгай зөвшөөрөл эзэмшигч “МОНЦЕМЕНТ БИЛДИНГ МАТЕРИАЛС” ХХК нь “Монполимет” группын охин компани бөгөөд 2012 онд Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших “Сэнжит худаг”-ийн шохойн чулууны ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж ордын бодитой (В) зэргийн бүх нөөцийг нийт 123.1 сая.тн шохойн чулуу байна гэж Монгол Улсын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлөөр батлуулсан. Энэхүү төслөөр ашиглалтын эхний 20 жилийн хугацаанд 1.9 сая.м³ хөрс хуулж, 24.8 сая.тн шохойн чулуу олборлоно.

1.2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Төслийн талбай орших газрын засаг, захиргааны харьяалал

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 500 орчим км, Дорноговь аймгийн төвөөс 60 км, Өргөн сумын төвөөс зүүн тийш 3 км-т байрлана. Улаанбаатар Замын-Үүдийн төв магистрал төмөр зам, авто замаас зүүн тийш шороон замаар холбогдсон.


Хүснэгт 2. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол

Талбайн дугаар, хэмжээ (га)	Булангийн цэгийн дугаар	Солбилцолууд	
		Х	Ү
MV-13681 458.44 га	1	110° 48' 15''	44° 44' 10''
	2	110° 49' 50''	44° 44' 10''
	3	110° 49' 50''	44° 42' 55''
	4	110° 48' 15''	44° 42' 55''

Дэд бүтэц, зам харилцаа

Хүн амын байршил сийрэг 1 ам.км талбайд 0.4 хүн оногдоно. Нутгийн оршин суугчид нь халхчууд байх бөгөөд олонхи нь мал аж ахуй эрхлэж нүүдлийн соёл иргэншлэлээр амьдардаг. Сумын төвд оршин суугчид нь уул-уурхайн жижиг үйлдвэрүүд, төмөр замын өртөө болон орон нутгын захиргаа, үйлчилгээний нэгдэл, соёл үйлчилгээний байгууллагуудад ажилладаг.

Төслийн талбай нь ой мод байхгүй учраас барилгын болон бусад өргөн хэрэглээний модон материалыг эх орны хойд хэсгээс эсвэл хятад улсаас төмөр замаар тээвэрлэн авчирдаг. Үйлдвэрийн ба ахуйн хэрэглээний нүүрсийг Налайх, Таван толгой, Багануурын уурхайгаас татаж ашиглана. Өргөн сумын төвөөс баруун тийш 53 км зайтай Түшлэгийн, 38 км зайтай Хамарын хурлын нүүрсний ордууд байдаг боловч одоогоор ашиглагдаагүй байна. Сумын төв, хайлуур жоншны уурхай, төмөр замын 43-р зөрлөг нь Сайншанд хотоос 380 вольтын өндөр хүчдэлийн шугамаар цахилгаан эрчим хүчээр хангагддаг.



Зураг 1. Төсөл хэрэгжиж буй орчны тойм

Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал

Төслийн талбай нь хойноосоо урагшаа намссан ухаа гүвээ гадаргатай. Аман-Ус Сөгдөх, Хатуугийн төгрөг зэрэг газруудаар нам жижиг бэсрэг уулс дов толгодорхог гадаргуутай, говь хээрийн бүсэд хамаарагдана.

Газрын гадаргын үнэмлэхүй өндөр далайн түвшинээс дээш 960-1080 м-ийн хооронд хэлбэлзэнэ. Газрын гадаргын онцлог хэсэг нь ихэвчлэн мөлгөрдүү оройтой, налуу хажуутай, мезо-кайнозойн тунамал-терриген хурдас тархсан хөндий, ухаа гүвээт талархаг гадаргуу голлох ба хөндийн харьцангуй өндөржилт нь 10-30 м-т хэлбэлзэнэ.

Ус зүй: Судалгаанд хамрагдсан талбайд Баруун төгрөгийн уулан дахь 0.1 л/сек ундарга бүхий Улаан булаг-аас өөр байнгын ба түр зуурын урсгалтай гол горхи байхгүй. Харин ихэнхдээ сул давсархаг устай хэд хэдэн худаг байдаг. Ундны усны гол эх булаг нь Өргөн сумаас зүүн хойш 3 км-д оршдог 3.3 л/сек ундаргатай Дэрсэн усны худаг юм.

Цаг Уурын байдал: Судалгаа явуулсан нутаг нь эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай бөгөөд хоногийн болон сар, жилийн дундаж температурын хэлбэлзлэл ихтэй, хур тундас бага унадаг. Хүйтний эрч 12, 1, 2-р сард чангарна.

Хамгийн хүйтэн нь 1-р сард ба олон жилийн дундаж температур -19.1°C -д хүрнэ. Хамгийн дулаан 7-р сард болдог ба олон жилийн дундаж температур $+21.1^{\circ}\text{C}$ -д хүрнэ. Жилийн тундасны дундаж хэмжээ 113 мм-т хүрэх бөгөөд түүний 90 хувь нь V-IX сард, үүнээс VI-VII саруудад илүү ихээр унадаг. Анхны цас 11-р сарын эхээр унаж 4-р сарын эхээр хайлж дуусдаг. Өвлийн улиралд хөрсний хөлдөлтийн гүн 1.6- 2.4м хүрэх ба 6-р сард бүрэн гэсдэг.

Ургамал зүй: Судалгаанд хамрагдсан нутаг дэвсгэр нь тачир сийрэг ургамалтай, өнгөн хөрсний үеийн зузаан 0.05-0.5м.

Тал хөндий, энгэр ээвэр бэл газраар таана, хөмүүл, агь, толгодын оройн хэсэг хажуугаар хялгана, хазаар өвс, монгол өвс голлож ургана. Бутлаг ургамлаас бударгана, шаваг, алтан харгана тархмал ургана. Хөндийн хуурай сайруудыг дагаж ганц нэг хайлаас ургасан тохиолдоно.

Амьтан судлал: Төв Азийн говь цөлийн бүсийн араатан амьтан, өвсөн тэжээлтэн, мэрэгчид, шавьж, хэвлээр явагчид, жигүүртэн зэрэг амьтад амьдардаг. Үүний дотор араатан амьтаны бүлгээс үнэг, хярс, хааяа чоно, өвсөн тэжээлтнээс туулай, хар сүүлт, цагаан зээр, уулархаг газраар цөөн тооны аргал, угалз, мэргэчидээс төрөл бүрийн хулгана, алаг даахай, хэвлээр явагчидаас могой, янз бүрийн гүрвэлүүд, жигүүртнээс сар, талын бүргэд, харцага, болжмор, ногтруу, шаазгай, хэрээ болон олон төрлийн шавьжууд дайралдана.

Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагааны тухай мэдээлэл

Ордын нийт бодитой болон боломжтой /B+C/ зэргийн нөөцийг 249.40 сая.тн-оор АМГ-ын даргын 2012 оны 08 сарын 27-ны 494-р тушаалын дагуу Ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлжээ.

Ордын нийт бодитой /B/ зэргийн нөөцийг ил аргаар 1.3 сая.тн/жил-н хүчин чадлаар ашиглахад орд ашиглалтын хугацаа 90.4 жил гарах ба 2019 онд Гложекс ХХК-ниар орд ашиглалтын эхний 20 жилийн олборлолт, үйлдвэрлэлийн төлөвлөгөө, дэд бүтцийн шийдэл, эдийн засгийн тооцоололлыг тусгасан ТЭЗҮ хийгдсэн.

Ил уурхайн жилийн хүчин чадал 1.3 сая.тн байна. Төслийн хугацаанд нийт 24.59 сая.тн шохойн чулуу олборлож, 1.9 сая.м³ хөрс хуулна.

“Монцемент Билдинг Материалс” ХХК нь Сэнжит худгийн шохойн чулууны ордыг түшиглэн жилд 1 сая тонн цемент үйлдвэрлэх “Монцемент” төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Цементийн үйлдвэрийн эхний цементийн шугам 2015 оны 08 сарын 13-нд ашиглалтанд орж ажиллаж эхэлсэн.

Техник, тоног төхөөрөмж

Тус уурхайд өрөмдлөгийн ажилд 102-300 мм диаметр бүхий өрмийн хошуутай Ханжин /Hanjin/ фирмийн P4000 загварын 490 кВт-ын хөдөлгүүрийн чадалтай өрмийн машин, хөрс хуулалтын ажилд 1.3 м³ утгуурын багтаамжтай САТ фирмийн 329 загварын экскаватор, шохойн чулуу олборлолтонд 5.0 м³ утгууртай ОХУ-ын ЭКГ-5А загварын шууд утгуурт цахилгаан экскаватор, хөрс тээвэрлэлтийн ажилд 36 тн даацтай САТ фирмийн 769D загварын автосамосвал, шохойн чулуу тээвэрлэх ажилд 50 тн даацтай БНХАУ-ын HOWO ZZ50W загварын автосамосвал, хөрсний овоолгод асгац түрэх, тэсэлгээгээр үүсэх нурлын хормой шуух, зам талбай тэгшлэх ажилд САТ фирмийн D7R загварын бульдозер ажиллана. Ил уурхайн туслах ажилд зам тэгшилж засах автогрейдер, зам усалгааны, түлш цэнэглэгч зэрэг автомашинууд зэрэгнийг үйлдвэрлэлийн 10 ш техник, тоног төхөөрөмжжиллана.

Уурхайн ашиглалтын технологи

Тус уурхайн ашиглалтын системийн үндсэн элементүүдийг ордын хөрсний чулуулгийн физик-механикийн шинж чанар, ачилт тээврийн тоног төхөөрөмжийн параметр, технологийн схем, уулын ажлыг явуулах аюулгүй ажиллагааны нөхцөл зэргийг харгалзан тооцсон.

Шохойн чулууг ил аргаар олборлох бөгөөд уурхайн ашиглалтын системийн үндсэн элемент нь шимт хөрс хуулалт, тэсэлгээ, хөрс хуулалт, олборлолт, уурхайн тээвэр, овоолгын аж ахуй, зэргээс бүрдэнэ.

2. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн БОНБНУ тайлан болон тус тайланд тусгасан ОХШХ-г үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавин ажиллалаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн БОАЖЯ-ны сайдын А-618 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болгов. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгахыг эрмэлзэх бөгөөд байгаль орчныг хамгаалах тайланд хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллалаа.

“Монцемент билдинг материалс” ХХК -ийн “Сэнжит худаг” шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэрэгжүүлэхэд 39,560,000 төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 3. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төсөв /мян.т/	Тайлбар
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6400.0	
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3460.0	
3.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3500.0	
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	200.0	-
6.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2050.0	-
7.	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	850.0	-
8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө;	1100.0	
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	6500.0	-
10.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	15000.0	-
11.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	500.0	
2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн төсөв.		39560.0	

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлөх нь тогтоогдлоо. Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авна

3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанд ашиглах машин механизмуудын утаат яндангаас ялгарах хорт хийн агууламжийг бууруулах зорилгоор утааны янданг тусгай шүүлтүүрээр тоноглохын зэрэгцээ техникийн оношлогоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцөлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- Мөн уурхайн задгай талбайд олборлолтын үйл ажиллагаагаар ялгарах тоосны хэмжээг бууруулахын тулд задгай талбайг усалж, чийгтэй байлгах арга хэмжээ авах, аль болох богино хугацаанд нөхөн сэргээлт хийх

- Уурхайн үйл ажиллагаанаас агаарт тархах тоосны хэмжээг багасгах, салхиар дамжин хотын суурьшлын бүсрүү тархахаас сэргийлж уурхайн эргэн тойронд ногоон байгууламж барих

- Уурхайн шимт хөрсний болон гадаад овоолгын талбайг хуурай, салхи ихтэй, агаар мандал тогтворгүй үед усалж байх хэрэгтэй.

3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Шохойн чулуу олборлох уурхайн төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Төслийн явцад хөрсийг ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдал болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх.

- Уурхайгаас гарах шороог төслийн дагуу овоолгын талбайд зөв байрлуулан асгаж, дагтаршуулах, хур тунадас, салхины нөлөөгөөр үүсэх хагарал, хотойлт зэргийн шалтгааныг судалж түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх шаардлагатай.

- Бүтээгдэхүүн тээвэрлэх машины зөөвөрлөх талбайд орох, гарах маршрутыг нарийвчлан тогтоох, олон салаа зам гаргахгүй байх, машин механизмын үзлэг үйлчилгээ хийх талбайг тогтоож, тэнд хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх шаардлагатай.

- Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж, цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх

- Олборлолт дууссаны дараа уурхайд ашиглагдсан талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих зэргээр техникийн нөхөн сэргээлт хийх

- Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрыг өтөг бууцаар бордож, олон наст ургамлын үр цацах, мод бут суулгах зэргээр биологийн нөхөн сэргээлт хийх

- Уурхайн олборлолт, барилга байгууламж байгуулах явцад эвдэрсэн хөрсийг засч тэгшлэх, нөхөн сэргээх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх

- Хөрс хадгалах зориулалттай талбайг сонгохдоо салхи, усны нөлөөгөөр хөрс элэгдэл дорох нөхцлийг хамгийн бага байхаар төлөвлөх

- Шимт хөрсийг хамгаалахын тулд овоолгын өнгөн хэсгийг сэргээх, үүний тулд овоолгын гадаргуугийн хөрсөнд усалгаа хийх, тохиромжит ургамлын үр цацах, гадаргуугийн бүрхэвч бий болгох, хажуу бэлийг хамгаалах зорилгоор геоматериалаар хучих арга хэмжээ авах.

3.3 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Газрын доорх ус буюу ундны усны нөөцийг бохирдуулагч эх үүсвэр нь хөрсний бохирдол юм. Хөрсөн дээр асгарсан, гоожсон шатах, тослох материал түүний үе давхаргуудад шүүрэн нэвчиж газрын доорх усыг бохирдуулна. Нөгөө талаар бороо хурын ус чийг, хөрсөнд бий болсон дээрх бохирдлуудыг цааш дамжихад ихээхэн нөлөөлөлтэй байдаг тул нэн түрүүн хөрсийг шатах, тослох материалаар бохирдохоос хамгаалах, бохирдсон нөхцөлд нэн даруй арга хэмжээ авч байх шаардлагатай.

- Өөрийн ашиглалтын талбай дахь болон эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдтэй хамтран ажиллах.

- Ажилчид болон төслийн талбай түүний нөлөөллийн бүсэд байх талбай дахь ард иргэдийн унд ахуйн хэрэгцээний усны чанар нь стандарт, норм, нормативд нийцэх эсэхэд байнга хяналт тавьж ажиллана.

3.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн явцад ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах замаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ашиглалтын талбайн ургамал бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх, маршрутын зам гаргах

- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хогийн нэгдсэн цэг байгуулах, хогийг орчиндоо тархахааргүй байх талаар арга хэмжээ авах.

- Уурхайн ашиглалтын явцтай зэрэгцүүлэн нөхөн сэргээлтийн ажлын хийх,

- Ногоон байгууламж барих,

- Биологийн нөхөн сэргээлтэнд ашиглах ургамлыг сонгож, тарималжуулах

3.5 Шимт хөрс хуулалт хадгалалт

Төсөл нь байгалийн бүс бүслүүрийн ангилалаар говь цөлийн бүсэд хамаарах бөгөөд уг бүслүүрт говийн бор, говийн цайвар бор, цөлийн бор саарал, борзон хөрс зохилон тархдаг бөгөөд шимт хөрсийг тухай бүс бүслүүрийн онцлогоос хамааруулан 20 см-ээр MNS 5916:2008 стандарт шаардлагын дагуу хуулж хадгалахаар төлөвлөв.

Үржил шимт хөрсний овоолгыг үүсгэх болон хадгалахад дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Үржил шимт хөрс хуулалтыг стандартын дагуу хийх технологийг ажилтан, машин механизмын жолооч нарт эзэмшүүлэнэ.

- Шимт хөрсний овоолгыг газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу хуулж, хадгална.

- Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет, чулуу, барилгын болон хаягдалд дарагдаж бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлнэ. Тухайлбал үржил шимт хөрсний овоолгыг олон дахин зөөхгүйгээр тогтвортой хадгалах талбайд байршуулах ба уулын хажуу болон гуу жалгатай газар овоолгыг байршуулбал борооны болон үерийн усаар урсаж алдагдах тул ус зайлуулах суваг шуудуу татах, эсвэл усанд урсахааргүй газарт байршуулна.

- Шимт хөрсний овоолгын байршил, хэлбэр, хэмжээ нь түүний хамгийн сайн хадгалагдах нөхцөлийг хангасан байхаар хэлбэршүүлэх бөгөөд шимт хөрсний овоолгын өндрийг 5 метрээс илүүгүй байхаар үүсгэхэд 5.0 га талбайг эзэлж байгаа болно.

- Шимт хөрсийг салхины зонхилох чиглэлийн дагуу шимт хөрсний овоолгын гадна талаар салхиар тоос шороо дэгдэн, шимт хөрс алдагдахаас сэргийлж хашаа хамгаалалт хийж, овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлэн олон наст өвслөг ургамал тарьж хашаа хамгаалалт хийнэ.

- Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, тордолгоо, бүртгэл, хяналтын ажлыг байнга хэрэгжүүлнэ




Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан


Энэхүү сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайлан “Монцемент билдинг материалс” ХХК -ийн “Сэнжит худаг” шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө бөгөөд доорх хүснэгтэд тусгагдсан арга хэмжээг жил бүр хэрэгжүүлэн ажиллахаас гадна тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд нэг бүрчлэн тусгаж, биелэлтийн тайланд хэрэгжилтийн хэмжээ гүйцэтгэлийн талаар тодорхой тусгаж тайлагнаж байна.



Тухайн төслөөс үүсэх гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлсны үндсэн дээр сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулах талаар ерөнхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээг хугацаа болон зардал мөнгөтэй нь доорх хүснэгтээр үзүүлээ.



СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН




Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан



Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Байгаль орчныг хамгаалахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжү үлэгч	Хэрэгжү үлэх хугацаа ба давтамж	Нийт зардал /мян.төг/	Зураг
1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тайлан							
Төсөлд ашиглагдах хүнд даацын авто машин болон үйлдвэрийн техник, машин механизмаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Уурхайн бүх төрлийн машин механизмыг жилд нэг удаа үзлэг оношилгоо засвар үйлчилгээг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн ажиллах шаардлагатай.	1. 2022.05.02-нд Нийт 39 техникт-Авто тээврийн оношлогоо үзлэг хийгдсэн. 2. 3-р шатны үзлэг улиралд нэг удаа төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.	Уурхайд ашиглагдаж байгаа бүх машин техник	ЗМХ ХАБЭАО-ны хэлтэс	Жилд ҮО-1 удаа 3-р шатны үзлэг-Зудаа	1400.0	
Шохойн чулуу болон хаягдал чулуулаг, шимт хөрс тээвэрлэх үед хүнд даацын машин механикийн хөдөлгөөнөөр сул шороо үүсэж, тоосжилт ихсэж агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.	Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, замыг байнга засаж сайжруулах, мөн чийгшүүлж усалгаа хийх, тоос дарагч бодис ашиглах зэргээр сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой.	1. Үйлдвэрийн бүсэд хурдны хязгаарлалтын 6 тэмдэг тэмдэглэгээг байршуулсан. 2. Нэг замын бодлого хэрэгжүүлэн ажиллах үүднээс Өргөн сумын воган пирезр-1 талдаа 4км хүртэлх замыг түрж сайжруулсан.	Уурхай болон үйлдвэрийн бүсэд	Уурхай болон Үйлдвэр	Нийт 2-3 удаа	ҮАЗ-тусгагд сан.	
	Мөн байнгын ашиглалттай авто зам, авто зогсоолыг хатуу хучилттай болгох	1. Засмар замын сайжруулалтын хүрээнд үерийн далан шугам хоолой татах ажлыг /Нар урт ХХК/ хийж гүйцэтгэсэн. Нийт-4км	Үйлдвэрийн бүсэд	Нар урт ХХК		ҮАЗ-д тусгагд сан	

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Байгаль орчныг хамгаалахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжү үлэгч	Хэрэгжү үлэх хугацаа ба давтамж	Нийт зардал /мян.төг/	Зураг
<p>.Төслийн талбайн хөрс газрын гадрага олон машин техникийн нөлөөгөөр талхлагдах, олон салаа зам үүсэх сөрөг нөлөөтэй..</p>	<p>Үйлдвэрийн бүсэд ашиглагдах ердийн замуудыг тэмдэгжүүлж тогтсон нэг маршрутаар зорчих, тухайн замаар зорчих эрхтэй тээврийн хэрэгсэлд замын маршрутыг хэвлэмэл байдлаар өгөх, шаардлагагүй олон салаа зам үүсгэхгүй байх, маршрутаас өөр замаар юм уу эсвэл шинээр зам үүсгэн зорчсон тээврийн хэрэгсэлд хариуцлага тооцох.</p>	<p>Үйлдвэрээс уурхайн карьер хүртэлх нэг замын маршруттай бөгөөд Харуул хамгаалалтын пост ажилладаг. Олон салаа зам үүсгэхгүй байх тал дээр ХАЭАБОХ-ийн 7 хоногийн хурал дээр хэлэлцсэн.</p>	<p>Нийт төслийн хэмжээнд</p>	<p>Үйлдвэр болон уурхай</p>	<p>Тухай бүрд нь</p>	<p>900.0</p>	
Зардал						900.0	
3. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тайлан							

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Байгаль орчныг хамгаалахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжү үлэгч	Хэрэгжү үлэх хугацаа ба давтамж	Нийт зардал /мян.төг/	Зураг
<p>Төслийн нийт 20 жилийн хугацаанд цементийн үйлдвэрт 901,155.5 м³ ус шаардлагатай ба үүнээс 40,000 м³ усыг үйлдвэрийн хаягдал усыг цэвэршүүлэн буцаан ашиглах бөгөөд үлдсэн 861,155.5 м³ усыг гүний худгаас хангана. Энэ хэмжээгээр гүний усны нөөцөд сөргөөр нөлөөлнө.</p>	<p>Уурхайн гүний усны хэрэгдээг багасгах үүднээс цэвэршүүлсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх, ус бага ашигладаг тоног төхөөрөмжийг түлхүү ашиглах. Жил бүр ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг гаргаж хэрэглээг байнга хянаж байх хэрэгтэй.</p>	<p>1. 7 хоногт 1 удаа бүх гүний худгуудаар үзлэг шалгалт хийж, газар доорхи усны мониторингийн хэмжилт хийдэг ба сард нэг удаа сумын байгаль орчины байцаагчтай хамт явж тоолуурын заалтуудыг хянаж, баталгаажуулалт хийлгэдэг. 2. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022.08.31- ний өдрийн 09 дугаар албан даалгаврыг “Монцемент Билдинг Материалс” ХХК нь 9 дүгээр сарын 8,9- ний өдрүүдэд зохион байгууллаа.</p>	<p>Үйлдвэр болон уурхайн хэмжээнд</p>	<p>ЭХУХХ</p>	<p>Төлөвлөгөөний дагуу</p>	<p>800.0</p>	
<p>Газрын доорх усыг авч ашигласнаар газрын доорх урсцын горим алдагдах, нөөц багасах, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамжилтад сөргөөр нөлөөлж болзошгүй.</p>	<p>- Үйлдвэрийн болон ахуйн бохир ус дамжуулах, шугам сүлжээний ашиглалтад байнга хяналт тавьж, гэмтэж, эвдрэх, элэгдэх цоорохоос урьдчилан сэргийлэх - Усан хангамжийн худгууд дээр усны түвшиний хэмжилт, усны чанарын шинжилгээг хийх, хаягдал усанд усны чанарын шинжилгээ, хийлгэх - Үйлдвэрийн хөргөлтөөс гарч буй усыг үйлдвэрийн технологийн процесст эргүүлэн ашиглахын зэрэгцээ цэвэршүүлсэн саарал усанд жил бүрийн физик, хими, бактериологийн</p>	<p>1. 2022 оны 10-р сарын эхний байдлаар Монцемент үйлдвэрийн бохир ус цэвэрлэг байгууламж нь нийт 11884 м3 ахуйн бохир усыг хүлээн авч, цэвэршүүлсэн байна. 2. Гүний худгуудын гадна ба дотор цэвэрлэгээ болон ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг сард 1 удаа тогтмол хийдэг. 3. Улирал тутам Дорноговь аймгийн МХГ-т гүний худаг, цэвэршүүлсэн ус, ажилчидын хотхон, гал тогоо гэх мэт 5цэгээс дээж авч шинжилгээнд хамруулдаг. БОХШХ-ийн ажлын даалгаварын дагуу хяналт</p>	<p>Үйлдвэр болон уурхайн хэмжээнд</p>	<p>ЭХУХХ</p>	<p>төлөвлөгөөний дагуу</p>	<p>800.0</p>	

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Байгаль орчныг хамгаалахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжү үлэгч	Хэрэгжү үлэх хугацаа ба давтамж	Нийт зардал /мян.төг/	Зураг
	шинжилгээний дүнд тулгуурлан ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд усалгааны зориулалтаар ашиглах эсэхийг шийдэж байх	шинжилгээг тогтмол хийлгэдэг.		ЭХУХХ	төлөвлө гөөний дагуу		
Зардал						800.0	
4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тайлан							
Цаашид олон машин техник болон хүний хөл хөдөлгөөнөөс үүдэлтэйгээр барилга байгууламжуудын ойр орчмын ургамлан нөмрөг доройтох, элэгдэл эвдрэл талхагдалд өртөх	Нөлөөлөлд өртсөн зам талбайг тухай бүр нь нөхөн сэргээж одоогийн хэдийгээр үйлдвэр болон бусад талбайн ногоон байгууламж стандарт хэмжээнд хүрсэн ч боломжит газруудад ногоон байгууламжийг нэмэгдүүлснээр нөлөөллийг бууруулах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх сайн талтай учир жил бүр мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, туршилт судалгааны ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй.	2021-онд түүж хадгалсан хөмүүл, таанын үрийг ил талбайд тарилтанд гаргасан. 2. Намрын мод тарилт-Уур амьсгалын өөрчлөлтөд ажилтан бүрийн оролцоо 2022аянг зохион байгуулан ажилласан. Нийт 7 хэлтэс нэгжийн 104 ажилтан хамрагдсан. ЕБС-ийн V-р ангийн 12 сурагчдад Буйлс модны үр хэрхэн тарих талаар анхан шатны мэдээлэлийг өгч, тарилт хийсэн.	Нийт төслийн хэмжээнд	БОМ		2500.0	
Зардал						2500.0	

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Байгаль орчныг хамгаалахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжү үлэгч	Хэрэгжү үлэх хугацаа ба давтамж	Нийт зардал /мян.төг/	Зураг
4. Амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тайлан							
Үйлдвэр, уурхайн том машин техникийн нөлөөгөөр зэрлэг ан амьтадын тоо толгой буурах, үргэж дайжах сөрөг нөлөөтэй.	Амьтдын тоо толгой буурах, дайжих, амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомстохоос хамгаалж орон нутгийн байгаль хамгаалагчтай хамтран сургалт зохион байгуулах.	2022-онд Өргөн сумын ЗДТГ-ийн хамтын ажиллагааны хүрээнд 4000 боодол өвсийг буулгах, хураах ажилд нийт 17 ажилтан хамрагдсан.	Төслийн хүрээнд	Жилд	1	500.0	
Цахилгааны шугамууд дээр суусан махчин шувууд тогонд зохиулж үхэх, тоо толгой цөөрөх нөлөөлөл болзошгүй.	Монцемент төслийн хувьд томоохон цахилгааны шонгууд дээр шувуу үргээгч толь байршуулсан байна. Харин жижиг цахилгааны шугамууд дээр үргээгч тол байршуулаагүй байдал ажиглагдаж байсан учир жижиг цахилгааны шонгууд дээр үргээгч хадаасыг зөв байршуулах хэрэгтэй.	Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамнуудад 2022-онд шувуу үргээгч толь-20ш нэмж суурьлуулсан. /Нэг тулгуурт-2ширхэгээр/.	Төслийн талбайн хэмжээнд	ЭХУХХ	1-2	1000.0	
Зардал						1500.0	
5. Оршин суугчид болон ажиллагсдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал							
Үйлдвэрийн бутлалт, тээрэмдэлт, шатаах системийн хэсэгт ажиллах ажилчид тоосжилт, дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй ерөнхийдөө хүрээлэн буй орчны физик бохирдолттой хөдөлмөрийн	Хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж байгаа ажилчдыг жил бүр эрүүл мэндийн үзлэг болон бүрэн шинжилгээнд хамруулж байх шаардлагатай. Уг төсөлд нийт 335 хүн ажиллахаас уурхайд 145, үйлдвэрт 85 хүн ажиллахаар байна. Иймээс уурхай болон үйлдвэрт	2022-онд Хөдөлмөрийн сайдын 2015оны А/223 тоот тушаалын дагуу Ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 106 ажлын байранд ажилладаг 329 ажилтан хамрагдсан байна.	Төслийн уурхай болон үйлдвэрийн ажилчид	Жилд	1-2	ҮАЗ- тусгагд сан.	

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Байгаль орчныг хамгаалахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжү үлэгч	Хэрэгжү үлэх хугацаа ба давтамж	Нийт зардал /мян.төг/	Зураг
хүндэвтэр нөхцөлд ажиллах тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөж болзошгүй юм.	ажиллах 230 хүнийг хүнд нөхцөлд хамруулан авч үзлээ.						
Орчны болон ажлын байрны тоосжилт, Машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээ, тэнд гарч болох осол, эвдрэл, Машин механизм, тоног төхөөрөмжид гарах гэнэтийн осол, ус, цахилгаан, дулааны болон хүнсний хангамжийн тасалдал, саатал	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах, Хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган цаг үеийн байдалтай уялдуулан ашиглах	XX-ийн хувцасыг жилд 2 удаа олгодог. Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх сургалтыг 2022-онд 4 удаа Нийт 269 ажилтаныг хамруулан практик, онол хосолсон мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг гадны байгууллагатай хамтран зохион байгуулсан.	Төслийн уурхай болон үйлдвэрийн ажилчид	ХАБЭАБ ОХ	Жилд	1800.0	
Зардал						1.800	
Нийт зардал							6400.0

“Сэнжит худаг” шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг 6 400 000 төгрөгөөр зардал гарсан.

3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Технологийн замын усалгаа: Ус шүршигч машинаар замын гадаргууг усалж норгоно.

Д/д	Талбайн хэмжээ	Зарцуулсан хугацаа	Ноогдох ус	Үр дүн
1	1 метр ²	30 минут	0,6литр	Нийт тоосжилт 95% буурсан.
2	1 метр ²	3-4 цаг	2 литр	Нийт тоосжилт-74% буурсан.

Work Place Inspection Report / Ажлын байрны үзлэг № 21

Department / Хэлтэс: Inspection team/ шалгах баг: ХАБЗАБОХ
 Date/Огноо: 2022.09.23
 Inspection place/ Үзлэг хийсэн газар:
 Зөрчлийн тоо:
 Тайланг хэвлэсэн Огноо: 2022.
 Хува: /100% - 100%

Hazard Legend: Class A (Major-do Immediately) / Class B (serious) / Class C / Class D (minor)							
Аюулын зэрэг: A (сүрьеэгийн хэргээр) / B (санаатайдан) / C (сайжруулалт хийх) / D (хэрэг тогтмол хяналтаар)							
Non-STANDARD CONDITIONS / PERFORMANCE / СТАНДАРТ БУС НӨХЦӨЛ / ҮЙЦДЭЭ							
Item No	Hazard Class / Аюулын зэрэг	Location / Дугаар	Reason / Үзлэг	Reference / Үйлдвэр	Action Required / Шаардлагатай арга хэрэгсэл	Responsible person / Хариуцаж байна	Target Date / Арга хэрэгсэл явах өдөр
1. Байгаль орчин							
1	B		1тн-р савлах явцад материалын асгаралтай байлгах үүдэн тоосжилттой.		Товог төгсөрсөмөд тоогрсон хэсгээр уйцалгааг сайжруулах	УХМ М.Отгонбаяр	3 хоног



Талбайн хяналт-АБҮ-шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд

1. Чулуунцар бункер лүү буулгах үеийн тоосжилтыг дарах-Бороожуулагчийг ажилд оруулсан.
2. Хуваарийн дагуу-Замын усалгааг зуны улиралд өглөө оройд 2-3удаа тогтмол усалгааг хийж байна.
3. Дамжлагуудад суурьлуулсан том жижиг фильтерийн үзлэг хяналт тогтмол хийгдэж байна.
4. Ханцуйт фильтерүүдэд үзлэг хийн ханцуй солив.
5. Шохойн чулууны бутлуур дээр нэмэлт компрессор тавин фильтэрийн соролт сайжруулав
6. Чулуунцар ачилтын үйл явцыг зохион ил задгай чулуунцар тээвэрлэхийг зогсоов.




Талбайн дамжлага бүрийн фильтерийн үзлэг хяналтын ажлын явц



Бүнкэрүүдийг гагнаж битүүмж сайжруулав

Агаар орчин хамгаалах

БОХШ-ны орчны хэмжилт бүртгэлийн дэвтэрийн дагуу өдөр тутмын хяналтын мэдээг ССР-ийн хянах самбарын дагуу хөтлөлт хийж байна.



Төрөл	Агаарын температурын өөрчлөлт (°C)	Агаарын тусгай хяналтын үзүүлэлт (мг/куб м)	Самбарын үзүүлэлт (мг/куб м)	ТМБ	ТМБ
1.00	12.5	0.1	0.1	✓	✓
2.00	12.5	0.1	0.1	✓	✓
3.00	12.5	0.1	0.1	✓	✓
4.00	12.5	0.1	0.1	✓	✓
5.00	12.5	0.1	0.1	✓	✓
6.00	12.5	0.1	0.1	✓	✓
7.00	12.5	0.1	0.1	✓	✓
8.00	12.5	0.1	0.1	✓	✓
9.00	12.5	0.1	0.1	✓	✓
10.00	12.5	0.1	0.1	✓	✓
11.00	12.5	0.1	0.1	✓	✓
12.00	12.5	0.1	0.1	✓	✓
13.00	12.5	0.1	0.1	✓	✓
14.00	12.5	0.1	0.1	✓	✓
15.00	12.5	0.1	0.1	✓	✓
16.00	12.5	0.1	0.1	✓	✓
17.00	12.5	0.1	0.1	✓	✓
18.00	12.5	0.1	0.1	✓	✓
19.00	12.5	0.1	0.1	✓	✓
20.00	12.5	0.1	0.1	✓	✓
21.00	12.5	0.1	0.1	✓	✓
22.00	12.5	0.1	0.1	✓	✓
23.00	12.5	0.1	0.1	✓	✓
24.00	12.5	0.1	0.1	✓	✓
25.00	12.5	0.1	0.1	✓	✓
26.00	12.5	0.1	0.1	✓	✓
27.00	12.5	0.1	0.1	✓	✓
28.00	12.5	0.1	0.1	✓	✓
29.00	12.5	0.1	0.1	✓	✓
30.00	12.5	0.1	0.1	✓	✓

Төрөл	Агаарын температурын өөрчлөлт (°C)	Агаарын тусгай хяналтын үзүүлэлт (мг/куб м)	Самбарын үзүүлэлт (мг/куб м)	ТМБ	ТМБ
1.00	12.5	0.1	0.1	✓	✓
2.00	12.5	0.1	0.1	✓	✓
3.00	12.5	0.1	0.1	✓	✓
4.00	12.5	0.1	0.1	✓	✓
5.00	12.5	0.1	0.1	✓	✓
6.00	12.5	0.1	0.1	✓	✓
7.00	12.5	0.1	0.1	✓	✓
8.00	12.5	0.1	0.1	✓	✓
9.00	12.5	0.1	0.1	✓	✓
10.00	12.5	0.1	0.1	✓	✓
11.00	12.5	0.1	0.1	✓	✓
12.00	12.5	0.1	0.1	✓	✓
13.00	12.5	0.1	0.1	✓	✓
14.00	12.5	0.1	0.1	✓	✓
15.00	12.5	0.1	0.1	✓	✓
16.00	12.5	0.1	0.1	✓	✓
17.00	12.5	0.1	0.1	✓	✓
18.00	12.5	0.1	0.1	✓	✓
19.00	12.5	0.1	0.1	✓	✓
20.00	12.5	0.1	0.1	✓	✓
21.00	12.5	0.1	0.1	✓	✓
22.00	12.5	0.1	0.1	✓	✓
23.00	12.5	0.1	0.1	✓	✓
24.00	12.5	0.1	0.1	✓	✓
25.00	12.5	0.1	0.1	✓	✓
26.00	12.5	0.1	0.1	✓	✓
27.00	12.5	0.1	0.1	✓	✓
28.00	12.5	0.1	0.1	✓	✓
29.00	12.5	0.1	0.1	✓	✓
30.00	12.5	0.1	0.1	✓	✓

Тоос сорох фильтерүүд

Хяналтын бүртгэлийн хөтлөлт

Автотээврийн үндэсний төвийн 3 мэргэжилтэн Жилд 1 удаа хамрагдах Техникийн үзлэгт Том жижиг овоорийн 39 техник хамрагдсан.



Техникийн засвар үйлчилгээг шаардлага хангасан автограшид тогтмол хийж байна.

Хяналт шалгалт

1. Өргөн тээвэрлэх тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд хяналт тавих ажлыг ХАБ-ЗМ-ийн хэлтэстэй хамтран улиралд нэг удаа зохиан байгуулан ажиллаж байна. Үзлэг шалгалтыг тухай бүрд нь хийснээр учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.
2. Техникүүдийн бүрэн бүтэн байдал, гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс 3-р шатны үзлэгийг Үйлдвэрийн удирдлага болон ЗМХ, ХАБЭАБО-ны хэлтэс нэгжээс холбогдох албан тушаалтанууд газар дээр нь шалгалт хийсэн.




Хяналт шалгалтын явц

Байгаль цаг уурын нөхцөл: 2022 онд 4 сар болон 10 сард Үзэгдэх орчин хязгаарлагдмал болж уурхайн ажилчид нийт-2 удаа зогсолт хийсэн.



Дорноговь цаг агаар: <https://www.facebook.com/dornogovimet>



Дорноговь аймаг Өргөн сум: 7-р сард 3 удаа, 8 сард-3 хур тунадас бага хэмжээгээр орсон.
Хур тунадас бага орсон хуурайшилт ихтэй.


Хөрсөн бүрхэвч хамгаалах ажил

Хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэхийн тулд тос маслоны асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлэх, бохирдсон талбайг нэн яаралтай цэвэрлэх, үйлдвэрийн үйл ажиллагааны явцад тоног төхөөрөмж, техникүүдийн үйл ажиллагаанаас үүссэн тос маслыг тогтоосон хатуу хучилттай газар үүсч болох эрдлээс сэргийлэх, хяналт тавьж хөрсний бохирдол үүйсгэхгүйн тулд дараах арга хэмжээнүүдийг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Тос масло яаманд солих, битүүмжлэн хадгалах
- Техникийн засвар үйлчилгээг авто грашд тогтмол хийлгэж байх
- Авто грашны орчны цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол 14 хоногт 2-3 удаа хийх

Work Place Inspection Report / Ажлын байрны үзлэг № 21

Department / Хэлтэс: Inspection team/малрах баг: ХАБЭАВОХ
 Date/Огноо: 2022.10.13
 Location/байр: Үзлэг хийсэн газар
 Зөрчлийн тоо:
 Тайланг хаасан Огноо: 2022
 Хуви: 100% - 100%

Hazard Legend: Class A (Major-do Immediately) / Class B (serious) / Class C / Class D (minor)						
A/B зэрэг (хяналттай) / C-Сайжруулалт хийх / D зэрэг-Тогтмол хянах(бага)						
Non-STANDARD CONDITIONS / PERFORMANCE / СТАНДАРТ БУС НӨХЦӨЛ / ҮЙЦЭЛ						
Item No	Hazard Class / Аюулын түвшин	Incident / Дугаарал	Picture / Зураг	Performance / Гүйцэтгэл	Action Required / Шаарцлагатай арга хэмжээ	Responsible person / Зарчлагч хүн
1. Байгаль орчин						
1	C	Орчны бохирдол Хамагдал дугуй талбайг их хэмжээгээр үүссэн.			АХС Бүртгэлийн дагуу даргагийн шатны байгууллагад шилжүүлэх	Уурхай Ц. Болдбаатар
						7 хоног



АБҮ-ийн дагуу Засвар үйлчилгээг тогтмол авто грашид тогтмол хийж, 7 хоногт 2 удаа цэвэрлэгээ үйлчилгээг хийж байна.

ШТ-станц

Дтг	Мэргэжл	Бэлэн байгаа эсэх	Сайжруулалт хийх эсэх
1	Тусгаар	✓	
2	Авч нөхцөл үзлэг	✓	
3	Нөөцөл хөдөлгөөн үзлэг	✓	
4	Ажлын өрөөн	✓	
5	ШТС-ын байрны гадна бүрэн бүтэн байдал	✓	
6	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	
7	ШТС-ын гадна хэсэг	✓	
8	ШТС-ын бүрэн эхэл	✓	
9	Бэлэн ажил хийж эхэлсэн үзлэг	✓	
10	Ажлаарх үйл ажиллагаа	✓	
11	ШТС-ын гадна хэсэг тусгаарлагдсан байдал	✓	
12	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	
13	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	
14	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	
15	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	
16	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	
17	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	
18	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	
19	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	
20	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	
21	Тусгай гэрэлтүүлэг бүрэн эхэл	✓	

ШТС-ийн үйлдвэр/БМ-ийн
 ХАБ-ын үйлдвэр/БМ-ийн
 ШТС-ийн үйлдвэр/БМ-ийн

Х. Түвшинбаяр
 Л. Доржпүрэв
 /Б. Цыгвэр/



Шатахуун түгээх станц: Ажлын байрны үзлэгийн хяналтын хуудасны дагуу ХАБ-ажилтан, БОМ, Агуулахын ахлах ажилтан нар хамтарч ажилласан.

Аюул ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд шатахуун нөөцлөх савнуудыг цоож пайзны хяналт, элсний пошигнуудыг нэмэлтээр дүүргэх ажлуудыг хийсэн.

Усан орчин хамгаалах ажил

7 хоногт 1 удаа бүх гүний худгуудаар үзлэг шалгалт хийж, газар доорхи усны мониторингийн хэмжилт хийдэг ба сард нэг удаа сумын байгаль орчны байцаагчтай хамт явж тоолуурын заалтуудыг хянаж, баталгаажуулалт хийлгэдэг.



Усны сан бүхий газрын бохирдож, хомстохоос хамгаалах арга хэмжээ

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022.08.31- ний өдрийн 09 дугаар албан даалгаврыг “Монцемент Билдинг Материалс” ХХК нь 9 дүгээр сарын 8,9- ний өдрүүдэд зохион байгууллаа.

Шанаган могойт гүний худаг, Шанаган могойт усан сан, Шувуун хөөврийн булаг, HS-03, Хайлааст, Баргилт, Малчны худаг, Сэнжит гэсэн нийт 8 гүний худаг, усан бүхий газрын ойр орчинд үүссэн хог хаягдлыг нийт 20 орчим ажилчдын бүрэлдэхүүнтэйгээр цэвэрлэж, ойролцоогоор 0.7 тн хогийг тээвэрлэн хогийн цэгт хаясан.



Бүх нийтийн цэвэрлэгээний өдөрөөр -Хэлтэс нэгжүүдийн нийт-18 ажилчдыг хамруулан гүний худгуудын доторх талбай болон гадна талбайн их цэвэрлэгээг хийсэн.



Шувуун хөөврийн булгийн тэмдэгжүүлэлт хийсэн байдал

2022 оны 10-р сарын эхний байдлаар Монцемент үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламж нь нийт 11884 м³ ахуйн бохир усыг хүлээн авч, цэвэршүүлсэн байна.



Усны хяналт:
Улирал тутам Дорноговь аймгийн МХГ болон ОХШХ-ийн дагуу жилд-1 удаа гүний худгууд болон ахуйн уснуудын мониторингийн ажлууд тогтмол хийгдэж байна.



Дундын усан сангийн кабелин утаснууд зарим газруудад ил гарсаныг засварлаж, далдалсан.



Гүний худгуулын хаягжуулалтыг сэргээн засварлах ажил хийгдэж байна.



Шанаган могойт гүний худгийн гадна талбайд таригдсан Хайлаасны ургалт. Хайлаас мод: хөрс голохгүй, тэсвэртэй ургамлан хашлага болон ногоон байгууламжийн хүрээнд тарьж ургуулахад илүү тохиромжтой бутлаг мод юм.

Ургамал орчинг хамгаалах

Монцемент үйлдвэрийн хэмжээнд нийт 12 тарлийн 14600 гаруй мод бут тарьж ургуулж байна. Үүнд: Улаан сухай, Жигд, Буйлс, Гүйлс, Чацаргана, Хайлаас, Улиас, Шар хуайс, Заг, Хармаг-2 төрөл, Алимны модны суулгац гэх мэт.

Мод тарихаас илүү говийн нөхцөлд хэрхэн арчилж ургуулах нь илүү чухал байдаг бөгөөд усалгааг улирал бүрд харилцан адилгүй байдаг учир 1дэх өдөр болон 4дэх өдөр Бүх нийтийн мод усалгааны өдөр болгон зарласан.

БАТЛАВ-ҮЙЛДВЭРИЙН ЗАХИРАЛ САНСУ БЭ

ҮЙЛДВЭРИЙН ДОТОРХ БОЛОН ГАДНА ТАЛБAYН МОД БУТНЫ УСАЛГААНЫ ХУВААРЬ

Хавар			Зун			Навар			Өвөл		
III			VI			IX			XII		
I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог	I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог	I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог	I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог
LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV
IV			VII			X			I		
I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог	I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог	I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог	I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог
LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV
V			VIII			XI			II		
I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог	I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог	I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог	I-р Тасвог	II-р Тасвог	III-р Тасвог
LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV	LIV

7 Хоног бүрийн 1 дэх болон 4 дэх өдөр мод услах. /1 цагаас/

Боловруулсан: БО-ны мөргөжөөгч *Л. Вуулиг* Х. Бумэндэг
 Зөвшөөрсөн: ХАБ-ын ажлын ажилтан *М. 000* М. Энхбатар



Монцемент үйлдвэрийн дотор таригдсан Жигд, Буйлс мод.



Монголын улаан номд орсон Улаан сухай модны мөчрийг усанд хийх-чийг авхуулах, үндэслэхэд илүү үр дүнтэй байх зорилгоор. /сухайн мөчир-2000ш/

Сухайн мөчир бэлтгэх тарих

1. Мөчрийг 18-20см таашуу тайрч багцлах
2. Бэлтгэсэн мөчирөө чийг алдахгүйгээр битүүмжилж хадгалах
3. Хавар тарилт хийх

Тарих

1. Хоовоо бэлтгэх /15x18см/ хэмжээтэй
2. Ямар суулгац тарихаас хамааран хөрсөө бэлтгэх.
3. Бэлтгэсэн бортоготой хөрсөө услах, тарилт хийхэд бэлтгэх
4. Мөчирөө суулгах.

Тарилтын дараах арчилгаа

1. Усалгааг тогтмол 7 хоногт 2-удаа услах
2. Гербицид буюу хог ургамалыг 14 хоногт 1-2удаа түүх

Үрийн нөөц бэлтгэх

Модны үр: Жигд, Буйлс үрийн бүрэн болцоос хамааран үр түүж хадгалах ажил хийгдэж байна.

Говийн нөхцөлд ургасан модноос үр бэлтгэх нь олон талын давуу талтай юм. Үүнд:

1. Үрээр тарилт хийхэд ургах хувь: 80-90% байдаг
2. Тарилтын дараа ил талбайд гаргахад ургах чадамжийн хувьд: 90-95%.
3. Өвчин хортонд тэсвэртэй. гэх мэт.



Үр түүх явц.



Латин нэр: *Elaeagnus moorcrofti*

6-8 орчим метр өндөр ургадаг. Үр жимсний гадуур нь шар өнгийн хальстай. Үр нь судалтай, өндөг хэлбэртэй. 1.1 см урттай.

Ургах орчин:
Элсэрхэг баянбүрдийн
булаг, сайрын захаар тоорой
сухайн хамтаар ургана.

Буйлс: IV.20-с эхлэн
ягаан цэцгээр гоёдог.
Говийн хөрсөнд ургадаг
бутлаг мод юм



Шимт хөрс хуулалт, хадгалалт

2022 оны Уулын ажлын төлөвлөгөөний дагуу 7016м³-10сарын эцсийн байдлаар 5580м³ хуулсан байна.



Шимт хөрс ачилт, буулгалтын ажлын явц.

Тэмдэгжүүлэлт



Технологийн зам дагуух тэмдэгжүүлэлт.



Шимт хөрс хамгаалалтын ажлын хүрээнд 2022-онд ургамлан хашлага хийхээр БОМТ-нд тусгагдсан бөгөөд бэлтгэл ажлыг ханган сухай болон хайлаас модны тарилтыг Сэнжит уурхайн 12 ажилтан хийж гүйцэтгэсэн.



Тарилтын ажлын явц. /Зөөврийн усалгаагаар/

Техникийн хаягдлаас гарсан. Тосны шүүр.

Тосны шүүр, арматур ашиглан технологийн зам дагуу гэрэл ойлгогч байдлаар хог хаягдлыг дахин ашиглаж чадсан.

Эерэг үр дүн: Дахиварыг дахин ашиглах, жолоочийн холын зайн баримжааг сайжруулах зэрэг давуу талтай.




Гэрэл ойлгогч-Тосны шүүр ашиглаж хийсэн. Нэг замын бодлогыг хэрэгжүүлэн ажиллах. Олон салаа зам үүсгэхгүй байх.



Хурдны тэмдэгнүүдийг сэргээн засварласан.



2020-оны хавар Технологийн зам дагуу тарьсан жигд моднууд.



Мод ургамал нь агаарын чийгшийг 4-7% ихэсгэж, нарны хэт төөнөлтийг 10-15% бууруулдаг.

Зуны улиралд тоосны 50%

Өвлийн-37%-ийг өөртөө шингээдэг.

1 ширхэг мод жилд 120 гаруй кг нүүрстөрөгчийг шингээн авч, 104кг хүчилтөрөгч үйлдвэрлэдэг.

Навчит модны титэм дуу шуугианы 26%-ийг шингээж, 74% ойлгож сарниулана.

ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

